



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/242

Улаанбаатар хот

Төрийн албаны шалгалтын сэтгэцийн
эрүүл мэндийн дүгнэлтийн хүчинтэй
хугацааг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Чөлөөлье" санаачилгын хүрээнд эрүүл мэндийн байгууллагаас олгож буй сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийн хүчинтэй хугацааг Төрийн албаны ерөнхий шалгалтад оролцогчийн тухайд нэг жилээр, тусгай шалгалтад оролцогчийн тухайд зургаан сараар тус тус тогтоосугай.

2. Батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу Сэтгэцийн эмчийн орон тоог холбогдох журмын дагуу тогтмол нөхөх, хүний нөөцийн тогтвортой байдлыг ханган ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга (М.Наранпүрэв)-д үүрэг болгосугай.

САЙД  Э.БАТШУГАР

141260652